

2014 ОНЫ 11 дүгээр сард арилжаалах ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 сарын 21-ний өдрийн 389 тоот тогтоол болон Сангийн яамны үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлтийг үндэс болгон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10 сарын 23-ны өдрийн 169 тоот тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг бүртгэн авч дараах нөхцөлөөр үнэт цаасны анхдагч арилжааг хийхээр болсон байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр: Монгол Улсын Сангийн яам
2. Үнэт цаасны санал болгох хүрээ: Олон нийтэд санал болгох
3. Үнэт цаасны төрөл: Засгийн газрын энгийн үнэт цаас
4. Нэрлэсэн үнэ: 100,000 төгрөг
5. Нийт гаргах тоо: 1,000,000 ширхэг
6. Нийт үнийн дүн: 1,000,000,000,000 төгрөг
7. Үнэт цаасны үзүүлэлт:

№	ЗГҮЦ-ны төрөл	Тоо хэмжээ /ширхэг/	Үнийн дүн /сая төгрөг/	Хугацаа /7хоног/	Хүү төлөгдөх хэлбэр	Захиалга эхлэх өдөр	Арилжаа хаах өдөр
1	ЗГЭБ-Б-12-274	1,000,000	100,000.00	12	Хямдруулалттай	2014.10.29	2014.11.04
2	ЗГЭБ-Б-52-275	954,980	95,498.00	52	Сар бүр	2014.11.05	2014.11.11
3	ЗГЭБ-Б-12-276	952,676	95,267.60	12	Хямдруулалттай	2014.11.12	2014.11.18
4	ЗГЭБ-Б-28-277	-	-	28	Хямдруулалттай	2014.11.19	2014.11.25

8. **Хүүгийн хувь хэмжээ:** Долоо хоног бүр арилжигдах Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны хүүгийн хувь хэмжээ нь тухайн долоо хоногт Монголбанкнд арилжигдсан ижил хугацаатай ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүү байна. Хэрэв Монголбанкны тухайн долоо хоногийн арилжаа цуцлагдсан тохиолдолд ижил хугацаатай ЗГҮЦ-ны өмнөх арилжааны жигнэсэн дундаж хүүгийн хэмжээгээр тогтоогдоно.

9. **Захиалга авах хугацаа:** Монголын хөрөнгийн бирж нь тус арилжааны саналыг хуанлийн 6 хоногийн турш авна.

Захиалга хүлээн авах цаг: Лхагва гарагт – 14:00- 16:00 цагт

Пүрэв гараг- Дараа долоо хоногийн даваа гарагт- 10:00-16:00 цагт

Мягмар гарагт – 10:00-11:00 цагт

10. **Арилжаа хийгдэх:** Монголын хөрөнгийн биржийн арилжааны системд нийт захиалгыг хүлээн авсны дараа Сангийн яамнаас хуваарилалтыг хийнэ.